

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Долгор	Дугаар	L226
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Орхон сумын Халиун баг
Төрсөн газар	Орхон сум	Төрсөн он	1924
Ажил мэргэжил	Өндөр настан, эмэгтэй		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шандын дуган	Сүм хийдийн дугаар	БУОР 051
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ц.Мөнхбат

### Булган аймгийн Орхон сумын Шандын дуган

Мөнхбат: Шандын дуган Халиун багийн нутагт яг хаана байсан бэ, ямар лам нар ирж ном хурж байсан бэ?

Долгор: Лам нарыг одоо нэрийг нь сайн мэдэхгүй юм. Би хүүхэд болохоор лам нарын нэрийг нь сайн мэдэхгүй юм. Шандныхаа усны наад талд байсан.

Мөнхбат: Усны нэр бол Шандны ус нэртэй юу?

Долгор: Шанд л гэж нэрлэдэг юм.

Мөнхбат: Тэгээд л Шандны хурал гэдэг байж. Лам нар жилд хэдэн удаа ирж хурдаг байсан юм бол? Ямар ямар улиралд ирдэг байсан юм бол?

Долгор: Улиралын сайн мэдэхгүй юм. Өдөл нэг ирнэ, зун нэг ирнэ, намар нэг ирдэг юм шиг ер нь 2, 3 удаа ирдэг байсан.

Мөнхбат: Хаанаас ирдэг байсан юм бол? Ойр хавиас уу?

Долгор: Ойр хавийнхан л цуг

ларч байхгүй юу. Хурдаг хурдаг лам нар л ирж байсан.

Мөнхбат: Лам нар ингээд хуралаа хурчихаад явдаг байжээ. Тэр үеэр дуганыг харж үлддэг, одооныхоор манаач сахиулын үүрэгтэй тийм лам үлддэг л байсан байхдаа?

Долгор: Үлдэлгүй яах вэ, зул мулыг нь өргөдөг сахиул байна.

Мөнхбат: Нутгийн сүсэгтэн хүмүүс хэр очиж хуралд нь суудаг байсан бэ, таныг бага байхад?

Долгор: Зөндөө очино, хүүхдүүд ч их очино. Би чиг очдог байсан. Үхэр тэрэгтэй хэдэн хүүхдүүд цуглараад л, бидний хуралд суух ч яахав дээ, мөргөхөө ч мэдэхгүй, үхэр тэргэнд л суугаад очиж байсан юм.

Мөнхбат: Манж цавнаас нь хүүхэд байхдаа их хүртэж байв?